



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/437

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 2023 оны 12/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтай бидний нийтийн гэр” олон улсын зохицуулах зөвлөлийн 17 дугаар хуралдаанд аймгийн Засаг дарга болон холбогдох төлөөлөл, “Их Алтай-2023” олон улсын спорт, аялал жуулчлалын наадамд Ховд аймгийн баг тамирчид оролцох зардалд 16,911,000 төгрөг (арван зургаан сая есөн зуун арван нэгэн мянга)-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх зардалд зарцуулах 16,911,000 төгрөгийг Алтай бидний нийтийн гэр олон улсын залуучуудын спортын наадам зохион байгуулах, орон нутаг сурталчлах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 1051
Zah A/437 Ba



Аймгийн Засаг даргын 2023 оны
08 дугаар сарын 07-ны өдрийн
А/437 дугаар захирамжийн хавсралт

“АЛТАЙ БИДНИЙ НИЙТИЙН ГЭР” ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 17 ДУГААР
ХУРАЛДААН, “ИХ АЛТАЙ-2023” СПОРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардал	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	2	3	4	5
Алтай бидний нийтийн гэр олон улсын зохицуулах зөвлөлийн 17 дугаар хуралдаан (08 дугаар сарын 11)				
1	Буудал	140,000	140,000	Махсум зочид буудал 1 ортой ерөө (Засаг дарга)
2	Шатахуун	2,800	280,000	Махсум зочид буудал 2 ортой 2 ерөө (Ховд аймгаас төлөөлж оролцох албан хаагчид, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид багтаагүй)
3	Хоол	25,000	375,000	Ховд-Өлгий, Өлгий-Ховд, Өлгий хот доторх нийт 500 км явах
4	Орчуулагч	150,000	300,000	5 хүний, 08 дугаар сарын 11-ний өдрийн хоол, оройн хоол, 12-ны өдрийн хоол 3 удаа
5	Ховд бренд бүтээгдэхүүний дээж	50,000	1,000,000	08 дугаар сарын 11, 12-ны өдөр Алтайн Бүгд Найрамдах улс, Алтайн хязгаар, Казахстан, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төлөөллийн удирдлага багийн ахлагч дасгалжуулагч гэх мэт 1 аймгаас 5 хүнд нийт 20 гарын бэлэг
6	Гарын бэлэг	250,000	250,000	Алтайн Бүгд Найрамдах Улсын Засгийн газрын тэргүүн О.Л.Хорохординтой хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаа (08 дугаар сарын 11) Ховд аймгийн нэрийн бүтээгдэхүүн гар зураг/олбог

1	2	3	4	5
Их Алтай-2023 спорт аялал жуулчлалын тэмцээн (08 дугаар сарын 11-19-ний өдөр)				
7	Мандат	100,000	1,000,000	10 хүн тэмцээний журмын дагуу
8	Хувцас	400,000	4,800,000	12 хүний хувцас (тамирчид, дасгалжуулагч, Засаг дарга)
9	Хоол	40,000	4,000,000	10 өдөр 10 хүний хоол хоолны материал, газ, түлш,
10	Шатахуун	2,800	756,000	Ховд-Өлгий-Ховд гол-Бөхөн уул-Сагсай гол-Өлгий-Толбо нуур-Сайр хайрхан-Толбо нуур-Ховд аймаг нийт 900км зам туулна. 1 Пургон 100 км.т 20 литр 1 суудлын тэрэг 100 км.т 10 л нийт 270 л шатахуун шатахуун зарцуулна.
11	Багаж хэрэгсэл	3,000,000	3,000,000	Уулын авиралтын тоног төхөөрөмж, майхан
12	Гэр буудал	150,000	750,000	5 хоног Толбо нуурын жуулчны бааз
Нийт			16,911,000	